



# ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР

Зохицуулалттай этгээд

227



Салбарын төлөв

614.0 тэрбум  
төгрөгийн үнэ бүхий  
ҮХХ-ийг зуучлан  
худалдан, худалдан  
авч, шилжүүлжээ



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал



**98.5%**

Улаанбаатар хотод үйл  
ажиллагаа эрхэлж байна

Бодлого зохицуулалт



## САЛБАРЫН ТӨЛӨВ



УИХ-ын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт орсноор ҮХЭХЗ-ын байгууллага нь Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтад хамаарах болсон.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар анхны ҮХЭХЗ-ын байгууллагад тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд 2021 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 227 ҮХЭХЗ-ын байгууллага тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.

## Тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ-ын байгууллагууд:

Брокер  
**248**



Агент  
**1,272**



Нэг ҮХЭХЗ-ын байгууллага дунджаар 1 брокер, 5 агенттай ажиллаж байна. Хамгийн олон агенттай ҮХЭХЗ-ын байгууллагын агентын тоо 106 байна.



## ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ-ын байгууллагуудын 325 хувьцаа эзэмшигчдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 20.3 тэрбум төгрөг байна.

## ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮХЭХЗ-ЫН КОМПАНИУДЫН БАЙРШИЛ



СҮХБААТАР

71

ХАН-УУЛ

49

ЧИНГЭЛТЭЙ

29

БАЯНГОЛ

30

БАЯНЗҮРХ

40

СОНГИНОХАЙРХАН 5



### БАЙРШИЛ

Нийт тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ-ын байгууллагуудын 31.3 хувь нь Сүхбаатар, 21.6 хувь нь Хан-Уул, 12.8 хувь нь Чингэлтэй, 17.6 хувь нь Баянзүрх, 12.8 хувь нь Баянгол, 2.2 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт тус тус үйл ажиллагаа эрхэлж байгаа бол хөдөө, орон нутагт 3 ҮХЭХЗ-ын байгууллага буюу 1.3 хувь нь үйл ажиллагаа эрхэлж байна.

## БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/




### ШИГТГЭЭ

Хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2021 оны эхний 9 сард Монголбанк болон банкны эх үүсвэрээр нийт 787.2 тэрбум төгрөгийн зээлийг 10.5 мянган өрхөд олгосон бөгөөд 2021 онд сард дунджаар 87.9 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна.

**ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ,  
ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ**

Давхардсан тоогоор 2021 оны 3 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй байгууллага нийт 4,590 хэлцлээр, 759.2 мянган м.кв талбай, 614.0 тэрбум төгрөгөөр худалдан борлуулах үйл ажиллагааг зуучилсан байна.



**ТҮРЭЭСЛЭХ, ТҮРЭЭСЛҮҮЛЭХ, ХӨЛСЛӨХ,  
ХӨЛСЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ**

Тайлант хугацаанд нийт 1,511 хэлцлээр 125.2 мянган м.кв талбай, 13.33 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан хөлслүүлж, түрээслүүлэх үйл ажиллагааг зуучилсан байна..



Жич: Түрээсийн шимтгэл сарын түрээсийн дүнд нэг удаа суутгагдсан болно.

## БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



### ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- СЗХ-ны 2021 оны 363 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг шинэчлэн батлав.
- СЗХ-ны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг боловсруулж, цахим хуудсанд байршуулж, олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулсан.
- СЗХ-ны даргын 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 214 дүгээр тушаалын дагуу үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын стратеги бодлого, хууль тогтоомж, журам, дагаж мөрдөх шалгуур үзүүлэлт, стандартыг боловсронгуй болгох судалгаа шинжилгээ хийх, нэгдсэн мэдээллийн санг бий болгох чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.



### ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- УБЕГ-тэй 2021 оны 8 дугаар сарын 27-ны өдөр тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдийн бүртгэлийн асуудлаар цахим уулзалтыг зохион байгуулж нэгдсэн ойлголтод хүрсэн.
- Америкийн худалдааны танхимаас 2021 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан үл хөдлөх хөрөнгийн зах зээл сэдэвт дугуй ширээний уулзалт, ярилцлагад оролцож үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын оролцогчидтой мэдээ, мэдээлэл солилцов.



### ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- ҮХЭХЗ-ын үйл ажиллагаатай зохицуулах тухай хуулийн төсөл боловсруулах дотоодын зөвлөхийг сонгон шалгаруулсан. Зөвлөх үйлчилгээний хүрээнд нэр бүхий 2 улсын хууль эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулсан судалгааг гаргасан.

